

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ГЭЖ ямар байгууллага вэ?



Монгол Улсын Их Хурал гэж ямар байгууллага вэ?

Багшийн гарын авлага (12-14 нас)

Зорилт:

- Улсын Их Хурлын бүрэн эрх, бүтцийг нэрлэх
- Улсын Их Хурал үйл ажиллагаагаа хэрхэн явуулдгийг тайлбарлах



Сэдвийн агуулга:

- Улсын Их Хурлын бүрэн эрх
- Улсын Их Хурлын бүтэц, бүрэлдэхүүн

Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- "Монгол Улсын Их Хурал" видео

Сургалтын арга:

- KWL (Мэднэ, мэдэхийг хүсэж байна, мэдлээ) арга

Түлхүүр үг:

Улсын Их Хурал

Монгол Улсын парламент буюу хууль тогтоох дээд байгууллага. Монгол Улсын Их Хурал 76 гишүүнээс бүрдэнэ.

Парламент

Парламент бол өрд түмнийг төлөөлөн хууль тогтоох онцгой бүрэн эрх бүхий төлөөллийн байгууллага юм. Дэлхийн улс орнууд парламентаа өөр өөрсдийн хуулийн дагуу байгуулна.

Төлөөлөгч

Бусдыг төлөөлж, шийдвэр гаргахад иргэдийн нийтлэг хүсэл сонирхлыг илэрхийлж оролцохоор сонгогдсон хүн.

Хууль батлах (тогтоох)

Хуулийн төслийг парламентаар хэлэлцэж, батлах үйл ажиллагаа. Хууль тогтоох үйл ажиллагааны үе шат, дарааллыг парламентын дэгээр тогтоодог. Хуулийн төслийг парламент хэлэлцэхийн өмнө олон нийтээр хэлэлцүүлэх, тэдний саналыг авах зэргээр иргэдийн оролцоог хангадаг.

Үйл ажиллагаа

1. Сэдэлжүүлэлт

Дараах хүснэгтийг ашиглан сурагчидтай ярилцана. Үүнд:

Мэднэ

Парламентын талаар
сурагчдын мэдэж буй
гол зүйлийг
тэмдэглэнэ.

Мэдэхийг хүсэж байна

Тухайн сэдвийн
зорилтыг
тэмдэглэнэ

Мэдлээ

Хичээлийн
төгсгөлд сурагчид
зорилтын хүрээнд
юу мэдсэнээ
тэмдэглэнэ.

2. Шинэ мэдлэг бүтээх

- Сурагчдад "Улсын Их Хурал" видеог үзүүлнэ.
- Сурагчийн гарын авлагаас Улсын Их Хурал, түүний чиг үүргийн талаар
үншиж танилцуулсны дараах дараах асуултын хүрээнд ярилцана. Үүнд:
 - Улсын Их Хурал гэж юу вэ?
 - Улсын Их Хурал ямар чиг үүрэгтэй вэ?
 - Хууль батлах эрх яагаад зөвхөн Улсын Их Хуралд байдаг вэ?
 - Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын өмнөөс ганцаараа шийдвэр
гаргаж болох уу? Яагаад?

3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

Дасгал ажил 1.

"Монгол Улсын Их Хурал" үгийн сүлжээг сурагчдаар бөглүүлж, бөглөсөн
үгийн утгыг сурагчдаар өөрийн үгээр тайлбарлуулна.


Хяналтын асуулт:

1. Улсын Их Хурлыг яагаад "бага ард түмэн" гэж нэрлэдэг вэ?
2. Улсын Их Хурал юу хийдэг вэ?
3. Хууль батлах эрх яагаад зөвхөн Улсын Их Хуралд байдаг вэ?
4. Улсын Их Хурал шийдвэрээ хэрхэн гаргадаг вэ?

Дасгал ажил 1.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Асуултад хариулах, эсхүл хоосон зайд тохирох үгийг бөглөнө үү.



Овог, нэр: _____

Анги: _____

ХӨНДЛӨНГӨӨР

- 1 Улсын Их Хурлыг "....." гэж нэрлэх нь бий.
- 3 Улсын Их Хурлын 4 жил тутам болдог.
- 5 Улсын Их Хурал аливаа асуудлыг хэлэлцэн, саналаар шийдвэр гаргана.
- 7 Улсын Их Хурал баталсан хуулийнхаа хэрэгжилтийг үүрэгтэй.

БОСООГООР

- 2 Улсын Их Хуралд сонгогдсон ард түмний элч?
- 4 Ард түмнийг төлөөлж хууль батлах үүрэгтэй байгууллагын олон улсын нэршил?
- 6 Улсын Их Хурал хаана байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг вэ?
- 8 Юуг батлах эрх зөвхөн Улсын Их Хуралд байдаг вэ?

ХАРИУ:

Хөндлөнгөөр:

1. бага ард түмэн, 3. сонгууль, 5. Олонхын
- Босоогоор:
2. гишүүн, 4. парламент, 6. төрийн ордон, 8. Хууль